| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>174,971,600.00</b>   | <b>160,942,246.46</b>   | <b>160,942,246.46</b>   |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                   | 123,128,100.00          | 116,120,342.21          | 116,120,342.21          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                   | 12,960,900.00           | 12,208,232.33           | 12,208,232.33           |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                    | 10,368,700.00           | 9,168,506.12            | 9,168,506.12            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                 | 2,592,200.00            | 2,096,163.48            | 2,096,163.48            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                                | 25,921,700.00           | 21,349,002.32           | 21,349,002.32           |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>52,925,300.00</b>    | <b>49,479,093.00</b>    | <b>49,479,093.00</b>    |
| 210301      | Гэрэл, цахилгаан                                                     | 28,149,500.00           | 29,996,791.00           | 29,996,791.00           |
| 210302      | Түлш, халаалт                                                        | 19,533,400.00           | 15,333,847.00           | 15,333,847.00           |
| 210303      | Цэвэр, бохир ус                                                      | 5,242,400.00            | 4,148,455.00            | 4,148,455.00            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>37,967,600.00</b>    | <b>37,967,600.0</b>     | <b>37,967,600.0</b>     |
| 210401      | Бичиг хэрэг                                                          | 3,175,000.00            | 2,127,412.00            | 2,127,412.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                     | 920,700.00              | 920,700.00              | 920,700.00              |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 3,024,300.00            | 889,800.00              | 889,800.00              |
| 210404      | Ном, хэвлэл                                                          | 26,942,200.00           | 26,935,300.00           | 26,935,300.00           |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 869,400.00              | 1,215,600.00            | 1,215,600.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 3,036,000.00            | 5,878,788.00            | 5,878,788.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>151,200,000.00</b>   | <b>151,194,789.0</b>    | <b>151,194,789.00</b>   |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                              | 105,400,000.00          | 105,394,789.00          | 105,394,789.00          |
| 210604      | Урсгал засвар                                                        | 45,800,000.00           | 45,800,000.00           | 45,800,000.00           |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                        | <b>22,108,700.00</b>    | <b>22,108,700.00</b>    | <b>22,108,700.00</b>    |
| 210702      | Дотоод албан томилолт                                                | 22,108,700.00           | 22,108,700.00           | 22,108,700.00           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>116,004,200.00</b>   | <b>115,670,949.00</b>   | <b>115,670,949.00</b>   |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 109,741,000.00          | 109,741,000.00          | 109,741,000.00          |

**Биологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|             |                                                   |                         |                         |                         |
|-------------|---------------------------------------------------|-------------------------|-------------------------|-------------------------|
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох          | 2,000,000.00            | 2,000,000.00            | 2,000,000.00            |
| 210803      | Даатгалын үйлчилгээ                               | 150,000.00              | -                       | -                       |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                        | 150,000.00              | -                       | -                       |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                   | 1,500,000.00            | 1,500,000.00            | 1,500,000.00            |
| 210807      | Газрын төлбөр                                     | 2,463,200.00            | 2,429,949.00            | 2,429,949.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>            | <b>14,810,000.00</b>    | <b>14,810,000.00</b>    | <b>14,810,000.00</b>    |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                 | 14,810,000.00           | 14,810,000.00           | 14,810,000.00           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                           | <b>2,820,000.00</b>     | <b>2,820,000.00</b>     | <b>2,820,000.00</b>     |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                     | <b>2,820,000.00</b>     | <b>2,820,000.00</b>     | <b>2,820,000.00</b>     |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал    | 2,820,000.00            | 2,820,000.00            | 2,820,000.00            |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>             | <b>1,868,892,900.00</b> | <b>1,713,512,542.46</b> | <b>1,868,892,900.00</b> |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | <b>1,868,892,900.00</b> | <b>1,713,512,542.46</b> | <b>1,868,892,900.00</b> |
| 310001      | Улсын төсвөөс санхүүжих                           | 1,868,892,900.00        | 1,713,512,542.46        | 1,868,892,900.00        |
|             | Тохируулгын дүн                                   |                         |                         |                         |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл |                         |                         |                         |
|             | Ажиллагсдын тоо                                   | <b>95.00</b>            | <b>95.00</b>            |                         |
|             | Удирдах ажилтан                                   | 1.00                    | 1.00                    |                         |
|             | Гүйцэтгэх ажилтан                                 | 82.00                   | 82.00                   |                         |
|             | Үйлчлэх ажилтан                                   | 12.00                   | 12.00                   |                         |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

| 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон |                                                                                                            |            | /төгрөгөөр/           |
|-------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----------------------|
| Код                                                   | Үзүүлэлт                                                                                                   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл             |
| <b>II</b>                                             | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                                                                   |            | <b>630,573,712.00</b> |
| <b>21</b>                                             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                                                       |            | <b>630,573,712.00</b> |
| <b>210</b>                                            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                                                     |            | <b>556,493,145.67</b> |
| <b>2104</b>                                           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                                                    |            | <b>6,000,000.00</b>   |
| 210406                                                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                                                |            | 6,000,000.00          |
| <b>2108</b>                                           | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                                            |            | <b>550,493,145.67</b> |
| 210801                                                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       |            | 550,493,145.67        |
| <b>213</b>                                            | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                                                    |            | <b>74,080,566.33</b>  |
| <b>2133</b>                                           | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                                                                       |            | <b>74,080,566.33</b>  |
| 213303                                                | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг                                                    |            | 74,080,566.33         |
| <b>I</b>                                              | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                                      |            | <b>630,573,712.00</b> |
| <b>1311</b>                                           | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                         |            | <b>630,573,712.00</b> |
| 131101                                                | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж                                        |            | 304,079,614.00        |
| 131104                                                | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |            | 137,764,095.00        |
| 131105                                                | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               |            | 188,730,003.00        |
| <b>III</b>                                            | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>                                                            |            | <b>-</b>              |
| 9                                                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                                                           |            | -                     |
| 10                                                    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                                                          |            | -                     |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Биологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад цалин хөлсийг татвар нийгмийн даатгалын тайланд үнэн зөв тайлагнах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийг шилжүүлэн бүртгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Дэлгэрмаа, аудитор М.Батмагнай, аудиторын туслах Э.Ундрах-Эрдэнэ, С.Номин, Б.Болорчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Биологийн хүрээлэн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Биологийн хүрээлэн нь 2015 онд үүсгэн байгуулагдаж Монгол орны амьтны аймгийн биологи, экологи онцлог, антропогены болон уур амьсгалын өөрчлөлт амьтны аймагт нөлөөлөх зүй тогтлыг судлан илрүүлж, амьд байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хадгалах, нөөц баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, амьтны гарал үүслийг тогтоох, генийн сан бүрдүүлэх, сэргээн үржүүлэх генетик үндэслэл боловсруулах зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус хүрээлэнгийн зорилго нь Монгол орны биологийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн үржүүлэх, биологи үндэслэл боловсруулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Ковид-19 цар тахлын улмаас санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэлийн тайлан, худалдан авах ажиллагааны тайланг аудитад ирүүлээгүйг тайлангийн хугацаанд залруулан авсан.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,402,216.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,022.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Биологийн хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,977.7 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, урьдчилж орсон орлогын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                            | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт           |
|-------------------------------------|---------------------|---------------------|--------------------|
| Б                                   | 1                   | 2                   | 3=2-1              |
| Авлага                              | 11,207.50           | 74,080.60           | 62,873.10          |
| Бараа материал                      | 82,999.50           | 75,235.70           | (7,763.80)         |
| Үндсэн хөрөнгө                      | 2,190,747.30        | 2,109,660.30        | (81,087.00)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                 | <b>2,284,954.30</b> | <b>2,258,976.60</b> | <b>(25,977.70)</b> |
| Урьдчилж орсон орлого               |                     | 73,050.40           | 73,050.40          |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,803,663.20        | 1,803,663.20        |                    |
| Хуримтлагдсан үр дүн                | (110,809.70)        | (209,837.80)        | (99,028.10)        |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү    | 592,100.80          | 592,100.80          |                    |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр өмч</b>  | <b>2,284,954.30</b> | <b>2,258,976.60</b> | <b>(25,977.70)</b> |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:



- Авлага дансны үлдэгдэл 74,080.6 мянган төгрөг болж 62,873.1 мянган төгрөгөөр өссөн нь Шинжлэх ухааны технологийн сан, Эрүүл мэндийг дэмжих сан, БШУЯ-ны хөтөлбөр арга хэмжээний зардлаас эрдэм шинжилгээ судалгааны ажлын санхүүжилт оны эцэст цуглаж зарцуулагдаагүй үлдэж Сангийн яамны татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлэн татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,109,660.3 мянган төгрөг болж 81,087.0 мянган төгрөгөөр буурсан нь төсөл хөтөлбөрийн нэмэлт санхүүжилтаас 154,747.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдан авсан, тайлант оны элэгдлийн зардал 235,834.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 73,050.4 мянган төгрөг болж 73,050.4 мянган төгрөгөөр өссөн нь Шинжлэх ухаан технологийн сан, Эрүүл мэндийг дэмжих сан, БШУЯ-ны хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн;
- Нийт орлого өмнөх оноос 372,553.0 мянган төгрөгөөр буюу 13.3 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 211,793.9 мянган, нэмэлт санхүүжилтийн орлого 163,159.0 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан;
- Нийт зардал өмнөх оноос 112,020.4 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь нэмэлт санхүүжилтийн данснаас ажилтнуудад нэмэгдэл цалин хөлс олгосонтой тус тус холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,016,966.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,016,966.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс цалин хөлстэй холбоотой зардлыг 73,366.4 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллыг 32,206.6 мянган төгрөг зэргээр нийт 105,573.0 мянган төгрөгөөр бууруулж 1,911,393.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор батлагдсан төсвийг 42,500.1 мянган төгрөгөөр бууруулан 1,868,892.9 мянган төгрөг болгон тодотгол хийсэн.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,868,892.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,868,892.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,713,512.5 мянган төгрөгийг зарцуулж 155,380.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,713,512.5 мянган төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлыг 151,595.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 155,380.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| №   | Хөтөлбөр, арга хэмжээний |                               | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл   | Зөрүү     | Биелэлт |
|-----|--------------------------|-------------------------------|-------------|-------------|-----------|---------|
|     | Код                      | Нэр                           |             |             |           |         |
| 1   | 71805                    | Шинжлэх ухаан, технологи      | 1,868,892.9 | 1,713,512.5 | 155,380.3 | 91.70   |
| 1.1 | 80101                    | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,820,628.9 | 1,665,248.5 | 155,380.3 | 91.70   |
| 1.2 | 80219                    | Харуул, хамгаалалтын зардал   | 45,444.0    | 45,444.0    |           | 100.0   |
| 1.3 | 80802                    | Ажил олгогчоос олгох тэтгэмж  | 2,820.0     | 2,820.0     |           | 100.0   |

/мянган төгрөг/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд шинжлэх ухаан технологийн сангийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилт 137,764.1 мянган, судалгаа, шинжилгээний гэрээт ажил гүйцэтгэсэн нэмэлт орлого 188,730.0 мянган, нэгдсэн үндэсний байгууллагын хүнс, хөдөө аж ахуйн газар болон гадаадын бусад төсөл хөтөлбөрүүдийн захиалгаар гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилт 304,079.6 мянган нийт 630,573.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 6,000.0 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 550,493.1 мянган нийт 556,493.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 74,080.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Тус нэмэлт санхүүжилтийн орлого нь Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд боловсрол ШУ-ны салбарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн биелэлтийн хувь 95.8 хувьтай байна.

Хүрэх үр дүнд бүрэн хүрч ажиллаагүй нь эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь болон хэвлүүлсэн бүтээлийн тооны биелэлт дутуу байгаатай холбоотой байна.

Тайлант онд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх тус хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал болон хөрөнгийн зардалд нийт 1,868,892.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,713,512.5 мянган төгрөг зарцуулж 91.7 хувийн биелэлттэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 4.1 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан төсвийг тус байгууллагад албан бичиг, шийдвэр хавсарган ирүүлдэггүй, төсвийн төсөлтэй

холбоотой тайлбар тодруулга авахгүй төсвийг үндэслэлгүй хасч төрийн сангийн системд оруулж байна.

Мөн тодотгосон төсвийг албан бичгээр хүргүүлдэггүй, ямар шалтгаанаар тодотгол хийсэн нь тодорхойгүй зэрэг хяналт тавихад хүндрэлтэй байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд дараах асуудлууд анхаарал татсан болно. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын дагуу 10-аас дээш хувийн хэмнэлт хийж ажилласан боловч ашиглалтын зардалд 20-иос доошгүй хувийн хийж ажиллаагүй буюу 7,138.5 мянган төгрөгийн хэмнэлтийг дутуу хийсэн;
- Нийт 6 төрийн бус байгууллагад 39,358.0 мянган төгрөгийг бараа, ажил үйлчилгээ худалдан авсан төлбөрт шилжүүлсэн. Үүний 33,835.0 мянган төгрөгийг машин түрээсийн төлбөрт шилжүүлсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь гадаад болон дотоодын төслийн санхүүжилтийг жил бүр нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч зарцуулдаг.

Зарцуулалтын эрхийн дийлэнхийг бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсний зардлын ангилалд эрх нээдэг тул тус ангиллаас цалин хөлс, томилолт, ашиглалт, эд хогшил худалдан авахтай холбоотой зардал, хөрөнгө худалдан авах зэрэг Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байгаа мөн үндсэн орон тооны ажилтнуудад нэмэгдэл хөлс олгогдож байгаа асуудал нь холбогдох хууль, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг бодлогын хүрээнд бүх хүрээлэнгүүдийн хувьд анхаарч үзэх шаардлагатай байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Биологийн хүрээлэн нь нийт 3,040,177.0 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 314,720.6 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Тээврийн хэрэгсэл түрээсээр ашиглах 25,660.0 мянган төгрөгийн гэрээг байгуулахдаа төсвийн шууд захирагч батлаагүй (эрдэм шинжилгээний ажилтан баталсан), гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тээврийн хэрэгсэл түрээсээр ашиглах болон бусад гэрээ хэлцлийг байгуулахдаа захирал баталж, гэрээ дүгнэсэн акт үйлдэн, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмж өгөх

2. Төслийн санхүүжилтийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс зардлын ангиллаас үндсэн орон тооны ажилтнуудад 99,166.6 мянган төгрөгийн цалин хөлсийг давхардуулан олгосон.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын 1.3. "...цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн ангиллын Хамаарахгүй зүйлс: Хувь хүнд ажил үйлчилгээний хөлс авсны төлөөсөнд олгож байгаа НДШ тооцогдох цалин хөлс, урамшуулал. Энэ нь 2101 "Цалин хөлс" бүлгийн харгалзах зардлын зүйлд бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг бодлогын хүрээнд бүх хүрээлэнгүүдийн хувьд анхаарч, Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг мөрдөж ажиллах, Албан шаардлага хүргүүлэх

3. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын дагуу 10-аас дээш хувийн хэмнэлт хийж ажилласан боловч ашиглалтын зардалд 20-иос доошгүй хувийн хэмнэлт хийж ажиллаагүй байна

Энэ нь тус тогтоолын 1.8 "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг мөрдөж ажиллах, засгийн газрын тогтоолын дагуу хэмнэлт хийх, Албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авалтын гэрээнд хяналт тавьж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай, шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс зардлын ангиллаас цалин хөлс олгосон нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын холбогдох заалттай, ашиглалтын зардалд 20-иос доошгүй хувийн хийж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 223,667.3 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илрүүлснээс 95,863.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, шилэн данстай холбоотой зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 127,803.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 7,565.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актын биелэлт 100.0 хувь, 490,493.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагын биелэлт 75.0 хувь, 184,491.3 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |                  | Биелэлт  |                  | Зөрүү    |     |             |
|-----------------|---------------------|------------------|----------|------------------|----------|-----|-------------|
|                 | Тоо                 | Дүн              | Тоо      | Дүн              | Тоо      | Дүн | Хувь        |
| Төлбөрийн акт   | 1                   | 7,565.6          | 1        | 7,565.6          |          |     | 100.0       |
| Албан шаардлага | 4                   | 490,493.0        | 3        | 490,493.0        | 1        |     | 75.0        |
| Зөвлөмж         | 5                   | 184,491.3        | 5        | 184,491.3        |          |     | 95.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>10</b>           | <b>682,549.9</b> | <b>9</b> | <b>682,549.9</b> | <b>1</b> |     | <b>90.0</b> |

Шилэн дансны мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус хүрээлэнгийн гадаад болон дотоодын төслийн санхүүжилтийн орлого буюу нэмэлт санхүүжилтийн орлого 2022 онд нэмэгдэх төлөвтэй байгаа тул зарцуулалтыг холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 372,466.3 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс, 361,044.8 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 2,004.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 9,417.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 6 алдаа, зөрчлийн дүн 11,421.5 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 24,022.2 мянган төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй дүгнэлт” өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 4 алдаатай холбоотой 361,044.8 мянган төгрөгийн алдааг залруулж дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүү үр дүнгийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн өмнөх оны үлдэгдлийг 335.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтаас төвлөрүүлсэн 74,080.6 мянган төгрөгийг урсгал санхүүжилтаас төвлөрүүлсэн дүнтэй нэгтгэн тайлагнасан;
- Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны тайлант үеийн үр дүн 196,045.1 мянган төгрөгөөр илүү тусгагдсан;
- Нийгмийн даатгал болон татварын тайланд 43,978.9 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнасан;
- Тайлант жилийн элэгдлийн зардлыг 1,290.7 мянган төгрөгөөр илүү тооцсон мөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдлийг 51.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Орлогоор хүлээн зөвшөөрөх 45,262.2 мянган төгрөгийг зардал бууруулж бүртгэсэн байна.

##### 4.2 Төлбөрийн акт

Томилолтын шатахууны төлбөрт ажилтанд олгосон 2,004.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн 2,004.0 мянган төгрөгийг буруутай этгээдээр төлүүлэх, төлбөрийн акт тогтоох

##### 4.3 Албан шаардлага

Аудитаар илэрсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн ирүүлээгүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэлийн тайлан, худалдан авах ажиллагааны тайланг аудитад ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-5 “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” 54.5.4 “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга”, 54.5.5 “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн, үнэн зөв бэлтгэн гаргах, Албан шаардлага хүргүүлэх

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Цалин хөлсний бүртгэлтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тайлан, цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 16,220.3 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү тайлагнаснаас санхүүгийн тайланд 3,892.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 1,232.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг илүү ногдуулсан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1. "Дараахь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна:1/Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор;1/Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

###### Өгсөн зөвлөмж:

Ажилтнуудын цалин хөлсийг татвар, нийгмийн даатгалын тайланд илүү тусгасныг залруулгын тайлан бэлтгэж баталгаажуулан, илүү ногдуулсан татвар нийгмийн даатгалыг буцаан залруулж, төсөвт хэмнэлт үүсгэх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;

##### 2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 5 нэр төрлийн нийт 4,291.9 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС 12 Бараа материал стандартын "Бараа материал гэдэг нь хөрөнгүүд юм: а/Үйлдвэрлэлийн процессод ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа б/ Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа в/ Хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулах буюу түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн шинж чанартай 5 нэр төрлийн нийт 4,291.9 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлэн бүртгэх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/


| д/д                                            | Байгууллагын нэр   | Аудитын код            | Алдаа, зөрчлийн утга                                                                                                                                                                                                                                               | Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга         | Нийт алдаа, зөрчлийн дүн |           | Үүнээс    |           |     |     |                 |     |                   |     |         |     |
|------------------------------------------------|--------------------|------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|--------------------------|-----------|-----------|-----------|-----|-----|-----------------|-----|-------------------|-----|---------|-----|
|                                                |                    |                        |                                                                                                                                                                                                                                                                    |                                                             |                          |           | Залруулга |           | Акт |     | Албан шаардлага |     | Хариуцлага тооцох |     | Зөвлөмж |     |
|                                                |                    |                        |                                                                                                                                                                                                                                                                    |                                                             |                          |           | тоо       | Дүн       | тоо | Дүн | тоо             | дүн | тоо               | дүн | Тоо     | дүн |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар</b> |                    |                        |                                                                                                                                                                                                                                                                    |                                                             |                          |           |           |           |     |     |                 |     |                   |     |         |     |
| 1                                              | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Санхүү үр дүнгийн тайланд Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн өмнөх оны үлдэгдлийг цахим системд тусгагдсан тайлангаас 335.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан тус дүнг Мэдээлэл, технологийн үйлчилгээ ангилалд тайлагнасан. | Санхүү үр дүнгийн тайланд залруулга хийсэн                  | 1                        | 335.5     | 1         | 335.5     |     |     |                 |     |                   |     |         |     |
| 2                                              | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтаас төвлөрүүлсэн 74,080.6 мянган төгрөгийг урсгал санхүүжилтаас төвлөрүүлсэн дүнтэй нэгтгэн тайлагнасан.                                                                                                                | Нэмэлт санхүүжилтаас төвлөрүүлсэн дүнг тусад нь тайлагнасан | 1                        | 74,080.6  | 1         | 74,080.6  |     |     |                 |     |                   |     |         |     |
| 3                                              | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны тайлант үеийн үр дүн 196,045.1 мянган төгрөгөөр илүү тусгагдсан                                                                                                                                                               | Өмчийн өөрчлөлтийн тайланд тайланд залруулга хийсэн         | 1                        | 196,045.1 | 1         | 196,045.1 |     |     |                 |     |                   |     |         |     |
| 4                                              | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Нийгмийн даатгал болон татварын тайланд 43,978.9 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнасан                                                                                                                                                                  | Нийгмийн даатгалын болон татварын тайланд нөхөн тайлагнасан | 1                        | 43,978.9  | 1         | 43,978.9  |     |     |                 |     |                   |     |         |     |
| 5                                              | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Тайлант жилийн элэгдлийн зардлыг 1,290.7 мянган төгрөгөөр илүү тооцсон                                                                                                                                                                                             | Элэгдлийн залруулан бүртгэсэн                               | 1                        | 1,342.5   | 1         | 1,342.5   |     |     |                 |     |                   |     |         |     |



|    |                    |                        |                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                        |   |          |   |          |   |         |   |  |  |  |   |         |  |
|----|--------------------|------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------|---|----------|---|---------|---|--|--|--|---|---------|--|
|    |                    |                        | мөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдлийг 51.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                        |   |          |   |          |   |         |   |  |  |  |   |         |  |
| 6  | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Орлогоор хүлээн зөвшөөрөх 45,262.2 мянган төгрөгийг зардал бууруулж бүртгэсэн байна.;                                                                                                                                                                                                                            | Хөрөнгөөр хүлээн зөвшөөрч залруулсан                                                                                                                                                                   | 1 | 45,262.2 | 1 | 45,262.2 |   |         |   |  |  |  |   |         |  |
| 7  | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Нийгмийн даатгалын тайлан, цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 16,220.3 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү тайлагнаснаас санхүүгийн тайланд 3,892.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 1,232.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг илүү ногдуулсан байна. | Ажилтнуудын цалин хөлсийг татвар, нийгмийн даатгалын тайланд илүү тусгасныг залруулгын тайлан бэлтгэж баталгаажуулан, илүү ногдуулсан татвар нийгмийн даатгалыг буцаан залруулж, төсөвт хэмнэлт үүсгэх | 1 | 5,125.6  |   |          |   |         |   |  |  |  | 1 | 5,125.6 |  |
| 8  | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Томилолтын шатахууны төлбөрт ажилтанд олгосон 2,004.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.                                                                                                                                                                    | Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсныг улсын төсөвт төвлөрүүлэх                                                                                                                                | 1 | 2,004.0  |   |          | 1 | 2,004.0 |   |  |  |  |   |         |  |
| 9  | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Үндсэн хөрөнгийн шинж чанартай 5 нэр төрлийн нийт 4,291.9 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.                                                                                                                                                                                   | Үндсэн хөрөнгийн шинж чанартай 5 нэр төрлийн нийт 4,291.9 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлэн бүртгэх,                                            | 1 | 4,291.9  |   |          |   |         |   |  |  |  | 1 | 4,291.9 |  |
| 10 | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр,                                                                                                                                                                                                                                  | Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54                                                                                                                                                  | 1 |          |   |          |   |         | 1 |  |  |  |   |         |  |

|                                                                         |                    |                        |                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                 |    |           |   |           |   |         |   |           |   |           |  |  |   |         |          |
|-------------------------------------------------------------------------|--------------------|------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|-----------|---|-----------|---|---------|---|-----------|---|-----------|--|--|---|---------|----------|
|                                                                         |                    |                        | арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг тус тус аудитад ирүүлээгүй мөн тооцооллын алдаатай толилуулсан                                                   | дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн, үнэн зөв бэлтгэн гаргах                                                                                                                            |    |           |   |           |   |         |   |           |   |           |  |  |   |         |          |
| Дүн                                                                     |                    |                        |                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                 | 10 | 372,466.3 | 6 | 361,044.8 | 1 | 2,004.0 | 1 |           |   |           |  |  | 2 | 9,417.5 |          |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> |                    |                        |                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                 |    |           |   |           |   |         |   |           |   |           |  |  |   |         |          |
| 11                                                                      | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Тээврийн хэрэгсэл түрээсээр 25,660.0 мянган төгрөгийн гэрээг байгуулахдаа төсвийн захирагч батлаагүй эрдэм шинжилгээний ажилтан баталсан, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.                          | Тээврийн хэрэгсэл түрээсээр ашиглах болон бусад гэрээ хэлцлийг байгуулахдаа захирал баталж, гэрээ дүгнэсэн акт үйлдэн, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөрчлийг давтан гаргахгүй байх | 1  | 25,660.0  |   |           |   |         |   |           |   |           |  |  |   | 1       | 25,660.0 |
| 12                                                                      | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Шилэн дансанд 5 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 82,200.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 232,520.6 мянган төгрөгийн 3 гүйлгээг дутуу байршуулсан байна. | Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах                                                                                            | 1  | 314,720.6 |   |           |   |         | 1 | 314,720.6 | 1 | 314,720.6 |  |  |   |         |          |
| 13                                                                      | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Төслийн санхүүжилтийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс зардлын ангиллаас үндсэн орон тооны ажилтнуудад 99,166.6 мянган төгрөгийн цалин хөлсийг гэрээт ажлын                                          | Холбогдох хууль, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг бодлогын хүрээнд бүх хүрээлэнгүүдийн хувьд анхаарч, Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх                                              | 1  | 99,166.6  |   |           |   |         | 1 | 99,166.6  |   |           |  |  |   |         |          |

|                 |                    |                        |                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                    |           |                  |          |                  |          |                |                  |                  |                  |                  |                 |                 |
|-----------------|--------------------|------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|------------------|----------|------------------|----------|----------------|------------------|------------------|------------------|------------------|-----------------|-----------------|
|                 |                    |                        | хөлс болон зөвлөх үйлчилгээний хөлс утгатайгаар олгосон.                                                                                                                                                                                                                                 | арга хэмжээг мөрдөж ажиллах                                                                                        |           |                  |          |                  |          |                |                  |                  |                  |                  |                 |                 |
| 14              | Биологийн хүрээлэн | АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ | Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын дагуу 10-аас дээш хувийн хэмнэлт хийж ажилласан боловч ашиглалтын зардалд 20-иос доошгүй хувийн хийж ажиллаагүй буюу 7,138.5 мянган төгрөгийн хэмнэлт дутуу хийж ажилласан байна | Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг мөрдөж ажиллах, засгийн газрын тогтоолын дагуу хэмнэлт хийх | 1         |                  |          |                  |          | 1              |                  |                  |                  |                  |                 |                 |
| <b>Дүн</b>      |                    |                        |                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                    | <b>4</b>  | <b>439,547.2</b> |          |                  |          | <b>3</b>       | <b>413,887.2</b> | <b>1</b>         | <b>314,720.6</b> | <b>1</b>         | <b>25,660.0</b> |                 |
| <b>Нийт дүн</b> |                    |                        |                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                    | <b>14</b> | <b>812,013.5</b> | <b>6</b> | <b>361,044.8</b> | <b>1</b> | <b>2,004.0</b> | <b>4</b>         | <b>413,887.2</b> | <b>1</b>         | <b>314,720.6</b> | <b>3</b>        | <b>35,077.5</b> |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 05/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/56/НА-ТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтын шатахууны төлбөрт ажилтанд олгосон 2,004,000.00 /хоёр сая дөрвөн мянга/ төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Биологийн хүрээлэнгийн анхан шатны баримтгүй зарцуулсан 2,004,000.00 /хоёр сая дөрвөн мянга/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биологийн хүрээлэнгийн захирал Д.Гантулга, нягтлан бодогч Ё.Гангамөрөн нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 23/АО150058  
АХГ-2022/56/НА-СТА-ТМЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэлийн тайлан, худалдан авах ажиллагааны тайланг аудитад ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" 54.5.4 "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга", 54.5.5 "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэсэн заалттай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд, иж бүрэн бэлтгэн толилуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биологийн хүрээлэнгийн захирал Д.Гантулга, нягтлан бодогч Ё.Гангамөрөн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 24/20150058  
АХГ-2022/56/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн хугацаанд нь байршуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 314,720,600.00 /гурван зуун арван дөрвөн сая долоон зуун хорин мянга зургаан зуу/ төгрөгийн ажил гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн мэдээлэх албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нягтлан бодогч Ё.Гангамөрөнд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биологийн хүрээлэнгийн захирал Д.Гантулгад даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 20/А0150058

Улаанбаатар хот

АХГ- 2022/56/МА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тээврийн хэрэгсэл түрээсээр ашиглах 25,660,000.00 /хорин таван сая зургаан зуун жаран мянга/ төгрөгийн гэрээг байгуулахдаа төсвийн шууд захирагч батлаагүй (эрдэм шинжилгээний ажилтан баталсан), гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тээврийн хэрэгсэл түрээсээр ашиглах болон бусад гэрээ хэлцлийг байгуулахдаа захирал баталж, гэрээ дүгнэсэн акт үйлдэн, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биологийн хүрээлэнгийн захирал Д.Гантулга, нягтлан бодогч Ё.Гангамөрөн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Т.ОДОНЧИМЭГ

9006109

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-33.Docx

001081634



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 21/20150058

Улаанбаатар хот

АХГ- 2022/56/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төслийн санхүүжилтийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс зардлын ангиллаас үндсэн орон тооны ажилтнуудад 99,166,572.00 /ерэн есөн сая нэг зуун жаран зургаан мянга таван зуун далан хоёр/ төгрөгийн цалин хөлсийг давхардуулан олгосон.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын 1.3. "цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн ангиллын Хамаарахгүй зүйлс: Хувь хүнд ажил үйлчилгээний хөлс авсны төлөөсөнд олгож байгаа НДШ тооцогдох цалин хөлс, урамшуулал. Энэ нь 2101 "Цалин хөлс" бүлгийн харгалзах зардлын зүйлд бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг бодлогын хүрээнд бүх хүрээлэнгүүдийн хувьд анхаарч, Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биологийн хүрээлэнгийн захирал Д.Гантулга, нягтлан бодогч Ё.Гангамөрөн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109  
\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-34.Docx

001081637





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 02/А0150058

Улаанбаатар хот

АХГ- 0002/56/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын дагуу 10-аас дээш хувийн хэмнэлт хийж ажилласан боловч ашиглалтын зардалд 20-оос доошгүй хувийн хэмнэлт хийж ажиллаагүй байна.

Энэ нь тус тогтоолын 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу хэмнэлттэй ажиллан, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биологийн хүрээлэнгийн захирал Д.Гантулга, нягтлан бодогч Ё.Гангамөрөн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Т.ОДОНЧИМЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-35.Docx

01081640